



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ТӨРИЙН АЛБАНЫ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА”

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ОРОН НУТАГТ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Аудитын код: ДГА-2020/09-НА

Цахим хуудас:
www.dornogovi.audit.mn

Дорноговь аймаг
2020 оны 12 сар

Дарга, тэргүүлэх аудиторын үүргийг
түр орлон гүйцэтгэгч: Т.Ган-Өлзий
Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Ахлах аудитор: Э.Энхцэцэг
Утас: 70523020 Цахим хаяг: enkhsetseg.e@audit.gov.mn

Аудитор: Т.Мөнхтогтох
Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn

Гэрээт ажилтан: З.Давааням
Б.Ариунбаатар

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгтийн товъёог	3
Хавсралтын товъёог	3
БҮЛЭГ А. Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагааг хууль, журмаар олгосон эрх, үүргийн хүрээнд бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай байна	6
А.1. Төрийн албаны салбар зөвлөлийн дотоод үйл ажиллагааг бодит үр дүнд чиглүүлэх шаардлагатай байна	6
А.1.1. ТАСЗ-ийн бүрэлдэхүүнийг салбар зөвлөлд харьяалалгүй төрийн байгууллагуудын төлөөллөөс бүрдүүлж, хараат бус байдлыг хангаж ажиллах нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй байна	6
А.1.2. ТАСЗ-ийн үйл ажиллагаа нь журмын дагуу явагдаж байгаа хэдий ч зохион байгуулсан ажлын үр дүнг баримтжуулах, СЗ-ийн гишүүдийг хариуцлагдажуулах ажил хангалтгүй байна	7
А.1.3. ТАСЗ-ийн үйл ажиллагаанд зарцуулах санхүүжилтийг журмын дагуу төлөвлөж, батлуулаагүй байна	9
А.2. ТАСЗ нь хууль, журмаар олгосон чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна	10
А.2.1. ТАТХ, тогтоомж, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, энэ талаар харьяалах байгууллагуудад мэргэшил, аргазүйн зөвлөгөө өгөх, ТАХ-ийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, сургалт сурталчилгаа зохион байгуулах чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан байна	10
А.2.2. Хяналт тавих, хяналт шинжилгээ үнэлгээ хийх талаар төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлээгүй байна	11
БҮЛЭГ Б. ТАСЗ-өөс хэрэгжүүлж байгаа хүний нөөцийн бодлогыг оновчтой зохион байгуулаагүй байна	11
Б.1. Хүний нөөцийн сангийн бүрэлдэхүүн, бүртгэл, хөдөлгөөнийг бүрэн хөтлөөгүй байна	11
Б.1.1. Төрийн байгууллагуудаас ТАХ-ын нөөцийн бүртгэл, хөдөлгөөнд орсон өөрчлөлтийн мэдээллийг тухай бүр үнэн зөв, бүрэн ирүүлээгүй байна	11
Б.1.2. ТАСЗ нь хүний нөөцийн бодлогын хүрээнд зэрэг дэв шинээр болон ахиулан олгох чиг үүргийг хэрэгжүүлүүлэхдээ холбогдох журмыг баримтлаагүй байна	13
Б.2. ТАСЗ нь сул орон тоог нийтэд зарлах үүргээ хангалттай хэрэгжүүлээгүйгээс төрийн байгууллагуудын үйл ажиллагааны тасралтгүй байдал алдагдах эрсдэл үүсэхээр байна	15
Б.2.1. Аймгийн хэмжээнд 2019 онд төрийн байгууллагуудаас ТЖА-ны 166 ажлын байрны сул орон тооны захиалгыг ирүүлсэн ч сонгон шалгаруулалтын зарыг ТАЗ-д хүргүүлээгүйгээс тусгай шалгалтыг зохион байгуулаагүй байна	15
Б.2.2. Ажлын байрны сул орон тоог нөхөхдөө журмын дагуу нэр дэвшүүлэхгүйгээр ТЖА-ны нөөцөд бүртгэлгүй иргэдийг томилсон байна	19
Б.2.3 ТЖА-д нэр дэвшүүлсэн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий этгээд чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна	21
Дүгнэлт	23
Зөвлөмж	24
Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал	26
Тайлан баталгаажуулсан тушаал	28

Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол Улс
АБТ	Ажлын байрны тодорхойлолт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АТТ	Албан тушаалын тодорхойлолт
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
НБХ	Нийгмийн бодлогын хэлтэс
ОБГ	Онцгой байдлын газар
ОН	Орон нутаг
СЗ	Салбар зөвлөл
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СЯ	Сангийн яам
ТА	Төрийн алба
ТАГ	Төрийн аудитын газар
ТАЕШ	Төрийн албаны ерөнхий шалгалт
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТАСЗ	Төрийн албаны салбар зөвлөл
ТАТХ	Төрийн албаны тухай хууль
ТАХ	Төрийн албан хаагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЖА	Төрийн жинхэнэ алба
ТЖАТ	Төрийн жинхэнэ албан тушаалтан
ТЗ	Төрийн захиргаа
ТЗАХ	Төрийн захиргааны албан хаагч
ТЗУХ	Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс
ТҮ	Төрийн үйлчилгээ
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УИХ	Улсын Их Хурал
ХБТХ	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХХҮГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
ХЭЗХ	Хууль эрхзүйн хэлтэс
ЦГ	Цагдаагийн газар
ШША	Шүүхийн шинжилгээний алба
ШШГА	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба
ЭМГ	Эрүүл мэндийн газар

Хүснэгтийн товъёог:

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Төрийн албаны салбар зөвлөлийн бүрэлдэхүүн	6
Хүснэгт 2	Төрийн албаны салбар зөвлөлийн гүйцэтгэх ажил үүрэг	7
Хүснэгт 3	2019, 2020 оны зарцуулалт	9
Хүснэгт 4	2020 онд зэрэг дэв шинээр болон ахиулан олгогдсон албан хаагчдын шалгуур хангасан байдал	14
Хүснэгт 5	Төрийн албаны ерөнхий шалгалтад бүртгүүлсэн, шалгалтад тэнцэж нөөцөд бүртгээгдсэн иргэдийн тоо	15
Хүснэгт 6	СЗ-ийн харьяа агентлаг, сумдын ЗДТГ-аас ирүүлсэн сул орон тооны захиалга 2019 он	16
Хүснэгт 7	Сумдын ЗДТГ, харьяа агентлаг, газруудаас ирүүлсэн сул орон тооны захиалга 2020 он	17
Хүснэгт 8	Төрийн албаны зөвлөлөөс нийтэд мэдээлж зарласан сонгон шалгаруулалтын зар	17
Хүснэгт 9	Түр орлон гүйцэтгэгчээр томилж ажиллуулсан албан хаагчийн судалгаа	20
Хүснэгт 10	Түүвэрт хамрагдсан байгууллагын 2019, 2020 онуудад шинээр томилогдсон иргэний бүртгэл	21

Хавсралтын товъёог:

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Хүний нөөцийн мэдээлэл шинэчлээгүй, өөрчлөлт хийгээгүй байгууллагуудын судалгаа	-
Хавсралт 2	2020 онд зэрэг дэв шинээр болон ахиулан олгосон албан хаагчдын судалгаа	-
Хавсралт 3	Сул орон тооны захиалгыг журмын дагуу ирүүлээгүй байгууллагуудын жагсаалт	-
Хавсралт 4	Удирдах ажилтны сонгон шалгаруулалтад оролцсон шаардлага хангаагүй албан хаагчдын судалгаа	-
Хавсралт 5	Төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтад оролцсон шаардлага хангаагүй албан хаагчдын судалгаа	-

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрх, Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/53 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Төрийн албаны салбар зөвлөлийн 2019, 2020 оны үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, аудитын тайланг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагааг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэх.
- ТАСЗ-өөс хэрэгжүүлж байгаа хүний нөөцийн бодлогын хэрэгжилт оновчтой байгаа эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад ТАЗ-ийн Дорноговь аймгийн салбар зөвлөлийн 2019, 2020 оны үйл ажиллагааг хамруулан шалгалаа.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 4000 дугаар стандартууд, Төрийн аудит: Тулгуур зарчим MNS 6817:2020, Нийцлийн аудитын зарчим MNS 6817-6:2020, МУЕА-ын 2016 оны А/146 тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын түр журам”-ыг баримтлан, холбогдох албан тушаалтантай ярилцах, тайлбар, тодруулга авах, судалгаа авч дүн шинжилгээ хийх, санхүүгийн анхан шатны баримтыг үзэж нягтлах, ажлын төлөвлөгөөг тайлантай тулган баталгаажуулах зэрэг арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулаа.

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- УИХ-ын 2019 оны 17 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан ТАЗ-ийн үйл ажиллагааны дүрэм
- ЗГХЭГ-ын дарга, ТАЗ-ийн даргын хамтарсан 2019 оны 34/31 тушаалаар батлагдсан ТЖА-ийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам
- ТАЗ-ийн 2019 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан ТЗ-ны албан тушаалд тавигдах тусгай шаардлага
- ТАЗ-ийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам
- ТАЗ-ийн 2019 оны 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан ТА-ны тусгай шалгалт өгөх, болзол, журам

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

- ТАЗ-ийн 2019 оны 15 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан ТА-ны ерөнхий шалгалт өгөх болзол, журам
- ТАЗ-ийн 2019 оны 16 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам
- ТАЗ-ийн 2019 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан ТҮ-ний байгууллагын ТШЗ-ийг сонгон шалгаруулах журам
- ТАЗ-ийн 2019 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан ТАЗ-ийн салбар зөвлөлийн ажиллах журам
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам.

Аудитын хөтөлбөрийг 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр батлуулж, гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатны ажлыг 2020 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийг хүртэлх хугацаанд ахлах аудитор Э.Энхцэцэг, аудитор Т.Мөнхтогтох, гэрээт аудитор З.Давааням, Б.Ариунбаатар нар хэрэгжүүлэн, аудитыг дарга, тэргүүлэх аудиторовн үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Ган-Өлзий удирдаж, аудитор Ч.Хэрлэнчимэг аудитын стандарт, арга зүйн дагуу үе шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Аудитын тайланг 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор нэгтгэн, холбогдох үе шатны хяналтаар баталгаажуулж, ТАЗ-ийн Дорноговь аймаг дахь Салбар зөвлөл болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

БҮЛЭГ А. ТӨРИЙН АЛБАНЫ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ, ЖУРМААР ОЛГОСОН ЭРХ, ҮҮРГИЙН ХҮРЭЭНД БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

А.1. Төрийн албаны салбар зөвлөлийн дотоод үйл ажиллагааг бодит үр дүнд чиглүүлэх шаардлагатай байна.

А.1.1. ТАСЗ-ийн бүрэлдэхүүнийг салбар зөвлөлд харьяалалгүй төрийн байгууллагуудын төлөөллөөс бүрдүүлж, хараат бус байдлыг хангаж ажиллах нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй байна.

МУ-ын Төрийн албаны тухай хуулийн 65.3-т “Зөвлөл нь хараат бус, бие даасан байгууллага бөгөөд ажлын алба, салбар зөвлөл, сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн нэгжтэй байна. Ажлын албаны дарга, салбар зөвлөлийн даргыг Зөвлөл томилж чөлөөлнө”, ТАЗ-ийн 2019 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “ТАЗ-ийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.8-д “Аймаг дахь салбар зөвлөл нь 9-11 хүртэл, яам, нийслэл дэх салбар зөвлөл нь 9-13 хүртэл хүний бүрэлдэхүүнтэй байна” гэж заасны дагуу ТАЗ-ийн 2019 оны 98 тоот тогтоолоор Дорноговь аймаг дахь салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, дараах бүрэлдэхүүнтэй томилсон байна.

Хүснэгт №1

№	ТАСЗ дэх албан тушаал	Нэр	ТА-д эрхэлдэг албан тушаал
1	Салбар зөвлөлийн дарга	Б.Ганзориг	Аймгийн ЗДТГ-ын дарга
2	Гишүүн	Н.Хонгорзул	Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга
3	Гишүүн	Д.Цэрэн	Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн дарга
4	Гишүүн	Ц.Сансармаа	Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ийн дарга
5	Гишүүн	Ч.Байгалтуяа	Аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн дарга
6	Гишүүн	Ц.Содхүү	Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга
7	Гишүүн	Ч.Ариунаа	Аймаг дахь ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор
8	Гишүүн	Д.Цэндмаа	Аймгийн ХХҮГ-ын дарга
9	Гишүүн	Г.Тунгалагтуяа	Сайншанд сумын ЗДТГ-ын дарга
10	Гишүүн	М.Мөнхбаяр	Аймгийн МХГ-ын дарга
11	СЗ-ийн нарийн бичгийн дарга	У.Шинэчимэг	Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн хүний нөөц, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн

ТАЗ-ийн 2020 оны 283 дугаар тогтоолоор салбар зөвлөлийн дарга Б.Ганзоригийг үүрэгт ажлаас нь чөлөөлж, үүрэг гүйцэтгэгчээр аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга, салбарын гишүүн Н.Хонгорзулыг томилсон байна.

УИХ-ын 2019 оны 17 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан ТАЗ-ийн үйл ажиллагааны дүрмийн 2.1.10-т “ТАЗ нь ТАТХ-ийн 66 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхээс гадна салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн нэгжийн удирдлагыг томилох, чөлөөлөх эрх эдэлнэ” гэж заасан.

Аймгууд дахь ТАСЗ-ийн нарийн бичгийн албан тушаалыг орон тооны албан тушаал болгож, аймаг дахь төрийн албаны хэмжээнд төрийн албаны бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг бүхэлд нь хариуцуулахаар зохион байгуулсантай холбоотой ТАЗ-ийн 2020.06.10-ны өдрийн 224 дүгээр тогтоолоор аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар Ц.Батсугирыг томилсон байна.

ТАЗ-ийн үйл ажиллагааны дүрмийн 5.9-д “СЗ нь үйл ажиллагаагаа хараат бусаар явуулна”, 5.10-т “Аймгийн ЗДТГ нь СЗ-ийг үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлөөр хангана” гэж заасан.

Гэтэл ТАЗ-өөс томилсон СЗ-ийн бүрэлдэхүүний 60 орчим хувь нь аймгийн ЗДТГ-ын бүтцийн нэгжийн ажилтнуудаас бүрдсэн байгаа нь МУ-ын Төрийн албаны тухай хуульд заасан ил тод, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх гэсэн төрийн албаны зарчим хангагдахгүй байх эрсдэл үүсэхээр байна. Тухайлбал: ТАСЗ-ийн хүний нөөцийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд ТЗАХ-чид зэрэг дэв шинээр болон ахиулан олгох санал гаргах ажлын хүрээнд авч үзэхэд 2019 онд төрийн байгууллагуудаас нийт 95 ТЗАХ-д зэрэг дэв олгуулах материал ирүүлснээс 58 албан хаагч, 2020 онд 55 санал ирүүлснээс 43 албан хаагч нь ТЕЗ-ийн харьяа байгууллагын албан хаагчид байх ба СЗ-ийн 4 гишүүний цалингийн нэмэгдлийн асуудлыг зөвлөлөөр хянаж шийдсэн байна.

А.1.2. ТАСЗ-ийн үйл ажиллагаа нь журмын дагуу явагдаж байгаа хэдий ч зохион байгуулсан ажлын үр дүнг баримтжуулах, СЗ-ийн гишүүдийг хариуцлагажуулах ажил хангалтгүй байна.

Дорноговь аймгийн ТАСЗ нь 2019, 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан нийтлэг үүргийн хүрээнд 20, нийтлэг эрхийн хүрээнд 10, тусгай үүргийн хүрээнд 15, нийт 45 арга хэмжээг тус тус хэрэгжүүлэхээр тусгасан байна.

ТАЗ-ийн 2019 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “ТАЗ-ийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 4 дүгээр зүйлд салбар зөвлөлийн дарга нь гишүүний ажил үүргийн биелэлтийг дүгнэж, урамшуулах, шаардлага тавих, хариуцлага хүлээлгэх асуудлыг зохих байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэхээр, харин СЗ-ийн гишүүн нь жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг ажил үүргийн хуваарийн дагуу хариуцан зохион байгуулах, гүйцэтгэхээр заасны дагуу СЗ-ийн даргын 2019.10.20-ны өдрийн тогтоолоор гишүүдийн ажил үүргийн хуваарийг баталсан байна.

Хүснэгт №2

Д/д	Гишүүдийн нэрс	Гүйцэтгэх ажил үүрэг
1	Д.Цэрэн	Төрийн байгууллагаас ТАХ-ийн ажиллах нөхцөл, баталгааг хангахад чиглэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангах
		ТАХ-дыг мэргэшүүлэх багц цагийн сургалтад хамруулах ажлыг мэргэжил арга зүйгээр хангах
		Ажлын байрны шинжилгээнд үндэслэн бүтэц, орон тоог оновчтой тодорхойлж байгаа байдал, АТТ боловсруулалтад хяналт тавих, мэргэжил арга зүйгээр хангах
		Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, үнэлж дүгнэх ажлыг арга зүйгээр хангах
2	Ц.Содхүү	ТЗАХ-дад зэрэг дэв олгох журмын хэрэгжилтэд хяналт тавих
		Тухайн жилд ТЗАХ-д зэрэг дэв олгуулах саналыг СЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх
		ТА-д анх томилогдон ажиллаж буй ТЗАХ-ыг тангараг өргүүлэх ажлыг зохион байгуулах
3	Ц.Сансармаа	ОН-ын төсөвт СЗ-ийн үйл ажиллагаанд шаардагдах төсвийг нэгтгэн батлуулах, санал гаргах
		СЗ-өөс гарч буй шийдвэр, тогтоолын эрх зүйн үндэслэлд дотоодын хяналт тавьж, арга зүйгээр хангах
		ТЖАХ болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг урьдчилан хянах, нотлох баримтыг бүрдүүлэн ТАЗ-д хүргүүлэх
4	Ч.Ариунаа	Төрийн нэрийн өмнөөс Шүүхэд нэхэмжлэл гаргах саналыг ТАЗ-д хүргүүлэх, энэ талаар арга хэмжээ авч ажиллах
		ТҮ-ний ТШЗ-ийг томилох, чөлөөлөх ажлыг мэргэжил арга зүйгээр хангах
		ТЗАХ-ийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журмын хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүйгээр хангаж ажиллах
5	Г.Тунгалагуяа	ТА-д туршилтын хугацаа хэрэглэх болзол журмын хэрэгжилтэд хяналт тавих
		Төрийн байгууллагуудад зохион байгуулах хяналт шалгалтын удирдамж боловсруулан хэрэгжүүлэх
		ТАСЗ-ийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах олон талт арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах

6	Н.Хонгорзул	Төрийн байгууллагын ёс зүйн зөвлөлийг мэргэжил арга зүйгээр ханган ажиллах, зөрчилд дүн шинжилгээ хийж, ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх саналыг боловсруулан хэрэгжүүлэх
		ТАХ-дад ёс зүйн чиглэлээр сургалт зохион байгуулах
		ТАХ-чид ёс зүйн хэм хэмжээг сахиулах ажлыг зохион байгуулах, энэ талаар үүрэг даалгавар, ага зүйн дэмжлэг үзүүлэх
7	Д.Цэндмаа	ТАХ-ийн тоо бүртгэлийн системийн талаар байгууллагуудад мэдээлэл хийж, хяналт тавих
		ТАХ-ыг шатлан дэвшүүлэхдээ чадахуйн зарчмыг баримталсан эсэхэд хяналт тавих
		ТАХ-ыг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журмын хэрэгжилтэд хяналт тавих, арга зүйгээр хангах
8	Ч.Байгальтуяа	Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд ТА3-өөс баталсан удирдамж, аргачлалын дагуу хяналт шинжилгээ хийх
		ТАХ-ын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах, арга зүйн зөвлөмж өгөх
9	М.Мөнхбаяр	СЗ-ийн тухайн жилд зохион байгуулах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж батлуулах, сургалтыг нэгдсэн удирдлагаар хангах
		СЗ-өөс ТАХ, иргэдэд хүргэх зөвлөмжийн төслийг боловсруулах

СЗ-ийн гишүүдэд хуваарилсан ажил үүргийн хэрэгжилтийг авч үзэхэд жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил үүргийг хэрхэн гүйцэтгэсэн талаар гишүүд тайлагнаагүй, СЗ-ийн дарга нь гишүүдийн ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэсэн нотлох баримт болон энэ талаар холбоотой архивын баримт байхгүй байна.

Мөн тус журмын 4 дүгээр зүйлд салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нь СЗ-ийн хуралдааны бэлтгэлийг хангах, хуралдааны шийдвэр тэмдэглэлийг зохих журмын дагуу албажуулах, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхээр заасан.

СЗ-ийн ажиллах журмын 5 дугаар зүйлд СЗ нь хамтын удирдлага бүхий байгууллага, үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд асуудлыг олонхын саналаар шийдвэрлэнэ, гишүүдийн олонх ирснээр хуралдааныг хүчинтэйд тооцно, хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлаар тогтоол, тэмдэглэл гаргахаар заасан.

ТАСЗ нь 2019 онд зэрэг дэв олгуулах санал уламжлах, ёс зүйн зөвлөл байгуулах, зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэх, ТАЕШ зохион байгуулах салбар комисс байгуулах, ажлын хэсэг байгуулах тухай нийт 4 тогтоол, 2020 онд ТАЕШ болон тусгай шалгалт зохион байгуулах комисс, маргаан шалгах комисс, ажлын хэсэг томилох, нэр дэвшүүлж санал болгох тухай 36 тогтоол гаргасан байх боловч СЗ-ийн хурлын тэмдэглэл хөтлөөгүй, гишүүдийн хэдэн хувийн ирцтэй хуралдаж, асуудлыг олонхын саналаар шийдвэрлэсэн эсэх нь тодорхой бус байна.

Аудитад хамрагдсан хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хэрэгжилтийг авч үзэхэд тайланд төрийн байгууллагуудын албан хаагчдыг хамруулсан сургалт, зөвлөгөөн зохион байгуулсан тухай дурдсан байх боловч 2019 онд зохион байгуулсан сургалтад хамрагдсан иргэдийн бүртгэл хөтлөөгүй, сургалтын тайлан бичээгүй, бусад чиглэлээр хийгдсэн ажлуудыг баримтжуулж, архивлах ажил хангалтгүй хийгдсэн байна.

Мөн журмын 6 дугаар зүйлд СЗ-ийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн мэдээг жил бүрийн 7 дугаар сарын 1-ний дотор, жилийн тайланг дараа жилийн 1 дүгээр сарын 15-ны дотор тус тус гаргаж ТА3-д хүргүүлэхээр заасны дагуу хугацаанд нь хүргүүлсэн байна.

ТАЗ-ийн 2014 оны 126 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Ажил дүгнэх журам, үзүүлэлт батлах тухай" журмын 4.6-д "СЗ-ийн үйл ажиллагааг үнэлж дүгнэсэн үнэлгээг ТАЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж, шагнаж урамшуулах, ажлын хариуцлага тооцох асуудлыг шийдвэрлүүлнэ" гэж заасан байх боловч аймгийн СЗ-ийн 2019, 2020 оны үйл ажиллагааг үнэлж дүгнэсэн талаар материал ирүүлээгүй байна.

А.1.3. ТАСЗ-ийн үйл ажиллагаанд зарцуулах санхүүжилтийг журмын дагуу төлөвлөж, батлуулаагүй байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн албаны салбар зөвлөлийн ажиллах журмын 7.1-т “Салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг аймгийн ЗДТГ, төрийн байгууллагын тухайн жилийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ”, 7.2-т “Салбар зөвлөл нь үйл ажиллагааныхаа жилийн төсвийн төслийг боловсруулж, аймгийн ЗДТГ, төрийн байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасан.

Гэтэл ТАСЗ-ийн төсвийн төслийг боловсруулж хүргүүлээгүй, салбар зөвлөлийн төсвийг аймгийн ЗДТГ-ын 2019, 2020 оны төсөвт тусгуулж батлуулаагүй байна.

ТАСЗ-өөс төрийн албаны ерөнхий шалгалтын бүртгэлийн хураамжийн 80 хувь болох 1.4 сая төгрөгийг 2019 онд, 2.9 сая төгрөгийг 2020 онд тус тус аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлж, холбогдох зардлуудыг санхүүжүүлсэн байна.

Харин аймгийн ЗДТГ-аас СЗ-ийн дарга, нарийн бичгийн даргын цалин, урамшуулалд 2019 онд 4,9 сая төгрөг, 2020 онд 9.2 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн ба ТАСЗ-ийн 2019, 2020 онуудын орлого, зардлын гүйцэтгэлийг харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №3

Д/д	Зардлын нэр	Мөнгөн дүн /мян.төг/	
		2019 он	2020 он
Төрийн албаны зөвлөлөөс шалгалтын үйлчилгээний хураамжийн 80 хувь			
1	Төрийн албаны ерөнхий шалгалтын хоол	379.5	569.0
2	Төрийн албаны ерөнхий шалгалтын бичиг хэрэг	-	321.0
3	Төрийн албаны ерөнхий шалгалтын мандат	41.8	-
4	Төрийн албаны ерөнхий шалгалтын цай, чихэр, кофе	145.0	190.6
5	Төрийн албаны ерөнхий шалгалтын маск, гар ариутгагч, бээлий, хаяг	-	463.5
6	Төрийн албаны ерөнхий шалгалтын шуудан холбооны зардал	-	400.0
7	ТАСЗ-ийн гишүүдийн урамшуулал	900.0	1,000.0
Нийт		1,466.3	2,944.1
Аймгийн Засаг даргын Тамгын газраас			
8	ТАСЗ-ийн дарга, нарийн бичгийн даргын цалин	4,980.4	9,230.9
9	ТАСЗ-ийн гишүүдийн оройн зоог	226.7	-
10	ТАЗ-ийн гишүүдийн хоол, буудлын хөлс	188.4	-
Нийт		5,395.5	9,230.9
Нийт дүн		6,861.8	12,175.0

Аймаг дахь ТАСЗ нь 2019 онд нийт 6,9 сая төгрөг, 2020 онд 12,2 сая төгрөгийг зарцуулсан байх боловч СЗ-ийн үйл ажиллагааны журмын 7.5-д "Салбар зөвлөл нь үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэлийн тайланг МУ-ын Төсвийн тухай хууль тогтоомжид заасан журмын дагуу эрх бүхий байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлэх" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргаагүй байна.

А.2. ТАСЗ нь хууль, журмаар олгосон чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

А.2.1. Төрийн албаны тухай хууль, тогтоомж, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, энэ талаар харьяалах байгууллагуудад мэргэшил, аргазүйн зөвлөгөө өгөх, ТАХ-ийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, сургалт сурталчилгаа зохион байгуулах чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан байна.

ТАЗ-ийн 2019 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “ТАЗ-ийн салбар зөвлөлийн ажиллах журам”-д заасны дагуу СЗ нь Төрийн албаны тухай хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, энэ талаар харьяалах байгууллагуудад мэргэшил, аргазүйн зөвлөгөө өгөх, ТАХ-ийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, сургалт сурталчилгаа зохион байгуулах чиг үүргийн хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Журмын 3.1.1-т төрийн албаны тухай хууль тогтоомж, бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, энэ талаар харьяалах байгууллагад мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх чиг үүргийн хүрээнд ТАЗ-ийн 2019 оны 01 тоот "Хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай" албан даалгавар, Төрийн албаны тухай шинэчилсэн хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хүргүүлсэн зөвлөмж, чиглэлийг СЗ-өөс төрийн байгууллагуудад 5 удаагийн албан тоотоор хүргүүлж, бүх сумдад дээрх хуулийн танилцуулга сургалтыг зохион байгуулсан байна.
- Журмын 3.1.3-т Салбар зөвлөл нь зохион байгуулалтын хүрээнд ТАХ-дад ёс зүйн хэм хэмжээг сахиулах ажлыг зохион байгуулах, энэ талаар үүрэг даалгавар өгөх чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан.

Дээрх чиг үүргийн хүрээнд ТАЗ-ийн салбар зөвлөлийн 2019 оны 02 дугаар тогтоолоор ТЗ-ны болон ТҮ-ний албан хаагчдын ёс зүйн дүрэм шинэчлэгдэн батлагдсантай холбоотой СЗ-ийн дэргэдэх ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилж, ёс зүйн зөвлөлийн ажиллах журмыг баталсан байна. Тус журмын зорилго нь ТЗ болон ТҮ-ний албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн гомдол, мэдээллийг хүлээн авч түүний үндэслэлтэй эсэхийг шалган тогтоож, тогтоол гаргах, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангуулах бөгөөд, ёс зүйн зөрчлийн тоон мэдээг хагас, бүтэн жилээр гаргаж, аймгийн ЗДТГ-ын цахим хуудсанд байрших ТАСЗ-ийн цэсэд байршуулахаар заасан байна.

ТА-ны шинэтгэлийг хэрэгжүүлэхэд ТАХ-ийн ёс зүйн хэм хэмжээг сахин ажиллах зорилтын хүрээнд ТАЗ-өөс харьяалагдах төрийн байгууллагуудын ёс зүйн тайланг нэгтгэх тухай чиглэл өгсний дагуу 26 төрийн байгууллагаас ТАХ-ийн ёс зүйг хангуулах талаар хийсэн ажлын тайланг ирүүлсэн байна.

- Журмын 3.7-д заасан ТАСЗ-ийн сургалт, судалгаа, сурталчилгаа хийх ажлын хүрээнд ТАЗ-өөс МУ-ын ТАТХ-ийн 37, 38, 39 дүгээр зүйлд заасан ТЖАХ-ийн нийтлэг эрх, үүрэг, үйл ажиллагаанд хориглох зүйлийн талаар ТАХ-дад сургалт зохион байгуулах чиглэлийн дагуу сумдын Засаг дарга, агентлагуудын эрх бүхий албан тушаалтанд үүрэг, чиглэл хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

А.2.2. Хяналт тавих, хяналт шинжилгээ үнэлгээ хийх талаар төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлээгүй байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 3 дугаар зүйлд хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд Төрийн албаны зөвлөлөөс баталсан аргачлал, удирдамжийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, ТАХ-ийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилт болон ТАТХ тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавихаар заасан.

2019, 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний СЗ-ийн нийтлэг үүргийн 2.1.3-т "ТА-ны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, түүний үр дүнг дээшлүүлэх, талаар санал зөвлөмж гаргаж холбогдох этгээдэд өгөх" гэсэн ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, хэрэгжилтийг сайжруулахаар тусгагдсан ч энэ чиглэлээр ажил хийгдээгүй, харин 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүний нөөцийн аудит хийхээр тусгасан ч КОВИД-19 цар тахлын улмаас шалгалтыг хойшлуулсан байна.

БҮЛЭГ Б. ТАСЗ-өөс хэрэгжүүлж байгаа хүний нөөцийн бодлогыг оновчтой зохион байгуулаагүй байна.

Б.1. Хүний нөөцийн сангийн бүрэлдэхүүн, бүртгэл, хөдөлгөөнийг бүрэн хөтлөөгүй байна.

Б.1.1. Төрийн байгууллагуудаас ТАХ-ын нөөцийн бүртгэл, хөдөлгөөнд орсон өөрчлөлтийн мэдээллийг тухай бүр үнэн зөв, бүрэн ирүүлээгүй байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам"-ын 2.1-д "Нөөцийн сан нь доор дурдсан бүрэлдэхүүн хэсэгтэй байна", 3.1.2-т "Энэ журмын 2.1.2, 2.1.3, 2.1.7-д заасан нөөцийн бүртгэл, хөдөлгөөнийг ТАЗ-ийн Ажлын алба, бусад нөөцийн бүртгэл, хөдөлгөөнийг харьяалах Салбар зөвлөл хөтөлнө" гэж заасан. СЗ нь дараах нөөцийн сангийн бүрэлдэхүүний бүртгэлийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Дээрх журмын 2.1.1-т заасан "Төрийн жинхэнэ албан тушаал эрхэлж байгаа албан хаагчийн нөөц"-ийн бүртгэлийг төрийн албаны зөвлөлийн <https://hr.csc.gov.mn> цахим сайтад байршуулж ажилласан байна.

ТАЗ, СЗ-өөс 2019, 2020 онд төрийн байгууллагуудад хүний нөөцийн бүртгэлийг шинэчилж, хөдөлгөөн өөрчлөлтийг тухай бүр хийх, бүртгэл хөтлөлтийг эрчимжүүлэх чиг үүргийг албан бичгээр удаа дараа өгсөн байх боловч зарим төрийн байгууллагууд мэдээллийг бүрэн шинэчлээгүй байна. /Хавсралт №1/

Аймгийн ТАСЗ-өөс дээрх хүний нөөцийн бүртгэлийн системд нэвтрэх нэр, нууц үг үүсгээгүйгээс Сайншанд сумын Захирагчийн ажлын алба, Хатанбулаг, Хөвсгөл сумдад үйл ажиллагаа явуулж байгаа нийт төрийн байгууллагуудын албан хаагчдын нөөцийн мэдээллийг авах боломжгүй байна.

- Журмын 2.1.5-д заасан “Төрийн албаны тухай хуулийн 62.1.4-т заасан болон Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу цэргийн тэтгэвэр тогтоолгож /дээд офицер, офицер, ахлагч/ төрийн жинхэнэ албан тушаалаас чөлөөлөгдсөн иргэний нөөц”-ийн бүртгэлийг авч үзэхэд СЗ 2019 онд 6 иргэнийг бүртгэсэн байх боловч аймгийн ШША-аас 2019 онд цэргийн тэтгэвэрт гарсан 3 иргэн, 2020 оны 05-10 дугаар саруудад тэтгэвэр тогтоолгосон ЦГ-ын 2, ОБГ-ын 2, ШШГА-ны 1, нийт 8 албан хаагчийн бүртгэлийг бүртгээгүй орхигдуулсан байна.
- Журмын 2.1.4-т заасан “Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн жинхэнэ албан тушаалаас түр чөлөөлөгдсөн албан хаагчийн нөөц”-ийн бүртгэлд 2019 онд 3 иргэн, 2020 онд 2 төрийн албан хаагчийг бүртгэсэн байна. Гэвч аудитын түүвэрт хамрагдсан 10 байгууллагаас тус мэдээллийг тодруулж авч үзэхэд аймгийн БОАЖГ, МХГ, ГХБХБГ-т тус тус 1 албан хаагч эрүүл мэндийн шалтгааны улмаас ажлаас түр чөлөөлөгдсөн байхад бүртгэл хийгээгүй орхигдуулсан байна.
- Журмын 2.1.6-д заасан “Эрх бүхий байгууллагын шийдвэрээр нөхөр /эхнэр/ нь өөр орон нутаг, гадаад улс, олон улсын байгууллагад шилжин ажиллах болсон, эсхүл гэр бүлийн хүнд өвчтэй аль нэг гишүүнээ асрах зайлшгүй шаардлагын улмаас төрийн жинхэнэ албанаас чөлөөлөгдсөн албан хаагчийн нөөц”-ийн бүртгэлд ТАСЗ 2019 онд 2 албан хаагчийг бүртгэсэн байна.

Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх дээрх журмын 3.5-д “Салбар зөвлөл нь нөөцийн бүртгэл, хөдөлгөөний тайланг тухайн оны 7 дугаар сарын 1, дараа оны 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор гаргаж ТАЗ-ийн Ажлын албанд хүргүүлнэ” гэж заасан, мөн ТАЗ-ийн 2019.11.19-ний өдрийн 01/1432 тоот албан бичгээр ТАЗ-ийн хүний нөөцийн мэдээллийг СЯ-ны ТАХ-ийн цалингийн нэгдсэн системтэй холбох ажилтай холбоотой төрийн байгууллагуудаар мэдээллийг бүрэн шинэчлүүлэх талаар чиглэл ирүүлсэн байх боловч СЗ нь тус хугацаанд 2019, 2020 оны хүний нөөцийн бүртгэл, хөдөлгөөний тайланг ТАЗ-д хүргүүлсэн эсэх нь тодорхойгүй байна.

Мөн дээрх журамд бүх шатны төрийн байгууллага нь нөөцийн бүртгэл, хөдөлгөөнд орсон өөрчлөлтийн мэдээг батлагдсан загварын дагуу хөтөлж харьяалах Салбар зөвлөлд хүргүүлэх, Салбар зөвлөл болон төрийн байгууллага нь төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн бүртгэл, хөдөлгөөнд өөрчлөлт орсон мэдээг Төрийн албаны зөвлөлийн Ажлын албанд тухай бүр ирүүлэхээр заасан.

Аймгийн ТАСЗ-өөс эрхэлсэн түшмэл, ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан хаагчийн нөөцийн судалгаа, 2019, 2020 онд төрийн албанд анх томилогдсон албан хаагчдын мэдээ, сумдын ЗДТГ, харьяа агентлаг, газруудад 2019 онд төрийн жинхэнэ албанд шинээр томилогдон ажиллаж буй түр орлон гүйцэтгэгч нарын судалгааг нэгтгэж хүргүүлсэн байх боловч төрийн байгууллагууд хүний нөөцийн бүртгэл, хөдөлгөөнд орсон өөрчлөлтийн мэдээг харьяалах Салбар зөвлөлд батлагдсан маягтаар тухай бүр ирүүлэх үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Аудитын түүвэрт хамрагдсан 10 байгууллагын хүний нөөцийн бүртгэлтэй холбоотой тайлан мэдээнээс харахад эдгээр төрийн байгууллагууд нь төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн бүртгэл, хөдөлгөөнд өөрчлөлт орсон мэдээг батлагдсан загварын дагуу хөтөлдөггүй, мэдээллийг шинэчлээгүй, тухай бүр хүргүүлж хэвшээгүй байна.

Б.1.2. ТАСЗ нь хүний нөөцийн бодлогын хүрээнд зэрэг дэв шинээр болон ахиулан олгох чиг үүргийг хэрэгжүүлэхдээ холбогдох журмыг баримтлаагүй байна.

ТАЗ-ийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны журмын 3.8-д хүний нөөцийн бодлогын хүрээнд дараах чиглэлүүдээр үүрэг хэрэгжүүлэхээр заасан. Үүнд:

1. Журмын 3.8.1-т “Төрийн алба, ТАХ-ийн талаарх мэдээ мэдээлэл, материал, судалгааг харьяалах байгууллагаас гаргуулж авах” гэж заасны дагуу ТАЗ-өөс 2019 онд хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчдын судалгаа, 2020 онд төрийн албаны чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн тухай, төрийн байгууллагын Ёс зүйн зөвлөлийн талаар, Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн хөрөнгөөр гадаад орнуудад сурсан болон сурч байгаа ТАХ-чид, тэдгээрийн ажил эрхлэлтийн байдлын талаарх мэдээллийг ирүүлэх чиглэлийн дагуу мэдээ, судалгааг тухай бүрд нь нэгтгэж хүргүүлсэн байна.
2. Журмын 3.8.2-т “ТЗАХ-чид зэрэг дэв шинээр болон ахиулан олгох санал гаргах” чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасны дагуу ТАСЗ-ийн 2019.03.21-ний өдрийн 1 дүгээр хуралдаанаар гишүүдийн 54 хувийн ирцтэйгээр ТЗАХ-дын зэрэг дэв олгох тухай асуудлыг хэлэлцэж, төрийн байгууллагуудаас нийт 101 материал ирүүлснээс сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй 5 албан хаагчийн материалыг буцааж, 96 материалыг үнэлэн дэмжиж, аймгийн Засаг даргын 2019 оны А/270 дугаар захирамжаар ахлах түшмэлийн 22, дэс түшмэлийн 50, туслах түшмэлийн 24 албан хаагчид зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох шийдвэрийг гаргуулсан байна.

Төрийн байгууллагуудаас 2019 онд ирүүлсэн зэрэг дэв олгох шалгууртай холбоотой архивын баримт материалыг ТАСЗ-өөс аудитын явцад гаргаж ирүүлээгүйгээс шаардлага хангасан албан хаагчдад тус нэмэгдлийг олгосон эсэхийг нотлох боломжгүй байлаа.

Харин 2020 онд нийт 23 байгууллагын, 67 ТЗАХ-д зэрэг дэв шинээр олгуулах, ахиулах санал ирүүлснээс шаардлага хангасан гэх 55 албан хаагчид зэрэг дэв олгох саналыг үндэслэн аймгийн Засаг даргын 2020 оны А/292 дугаар захирамжаар ахлах түшмэлийн 5, дэс түшмэлийн 32, туслах түшмэлийн 18 албан хаагчид зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох шийдвэр гаргаж, 12 албан хаагчийн материалыг өмнөх ангиллын албан тушаалд ажилласан хугацааны болон мөн журмын 2.5-д заасан шаардлага хангагдаагүй гэсэн үндэслэлээр шийдвэрлээгүй байна.

УИХ-ын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “ТЗ-ны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын 2.5-д “Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3-т заасан төрийн албанд ажилласан болон тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин болон мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1, 23.2.2, 23.2.3-т заасан тусгай шаардлагыг хангасан ТЗАХ-чид албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгоно” гэж заасныг зөрчин 2020 онд 26 албан хаагчийн өмнөх ангиллын албан тушаалд ажилласан хугацааны шаардлага хангагдаагүй байхад зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгосон байна.
/Хавсралт №2-т үзүүлэв/

**2020 онд зэрэг дэв шинээр болон ахиулан олгогдсон албан хаагчдын
шалгуур хангасан байдал**

Д/д	Зэрэг дэвийн ангилал	Хүснэгт №4	
		Захирамжаар зэрэг дэв олгогдсон тоо	Журмын шаардлага хангаагүй байгаа тоо
1	Ахлах түшмэлийн албан тушаалын зэрэг дэв шинээр олгох	1	1
2	Ахлах түшмэлийн албан тушаалын зэрэг дэв ахиулан олгох	4	3
3	Дэс түшмэлийн албан тушаалын зэрэг дэв шинээр олгох	14	9
4	Дэс түшмэлийн албан тушаалын зэрэг дэв ахиулан олгох	17	13
5	Туслах түшмэлийн албан тушаалын зэрэг дэв шинээр олгох	11	-
6	Туслах түшмэлийн албан тушаалын зэрэг дэв ахиулан олгох	8	-
Нийт		55	26

3. Журмын 3.8.3-т “ТАХ-ийг холбогдох журамд заасны дагуу шагнаж урамшуулах санал гаргах” гэж заасны дагуу 2019 онд ТА3-өөс ТА3-д 2 төрийн албан хаагчдыг “Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнуулахаар материал хүргүүлсэн боловч өнөөдрийг хүртэл шийдэгдээгүй байна.

4. Журмын 3.8.4-т “ТА3-өөс албан тушаалын тодорхойлолт хянах чиглэлээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх”-ээр заасан.

МУ-ын Төрийн албаны тухай хуулийн 23.4-т “ТЗ-ны албаны албан тушаалын тодорхойлолтыг энэ хуулийн 23.3-т заасан журамд нийцүүлэн боловсруулж, төрийн албаны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн тухайн албан хаагчийг томилох эрх бүхий этгээд албан тушаал тус бүрээр батална” гэж заасны дагуу ТА3-ийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын дагуу нутгийн захиргааны болон төрийн захиргааны байгууллагууд албан хаагчдын ажлын байрны шинжилгээг асуулгын аргаар хийж, нутгийн захиргааны 15 байгууллагын 157 албан тушаалд хамаарах 131 албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, ТА3-өөр батлуулсан байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 4.3-т “Баримт бичгийн бүрдэл дутуу, албан тушаалын тодорхойлолтын бүтэц агуулга оновчгүй буюу дутуу, албан тушаалд тавигдах тусгай шаардлага хууль тогтоомжид нийцээгүй тохиолдолд зөвлөмжийн хамт томилох эрх бүхий этгээдэд буцаана” гэж заасны дагуу ТА3-өөс 2020 онд сумын ЗДТГ-ын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтний талаарх зөвлөмж, аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргын албан тушаалын тодорхойлолтыг хянаж үзээд мэргэжлийн индексийг тодорхой болгох, мэргэшилд тавих шаардлагад салбарын болон төрийн удирдлагаар мэргэшсэн байх чиглэл оруулах, туршлагын шаардлагад удирдах албан тушаалын туршлагын хугацааг тодорхой болгох, сумдын Засаг дарга нарт дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг дахин шинэчилж, байгууллагын даргын тушаалаар батлах чиглэлүүдийг өгсөн байна.

Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журмын 5.1-т “Албан тушаалын тодорхойлолтыг томилох эрх бүхий этгээд шийдвэр гаргаж, албан тушаал тус бүрээр батална” гэж заасан байхад аймгийн хэмжээнд нийт хэдэн төрийн байгууллагын, хэдэн албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж батлуулсан тухай бүртгэл, мэдээлэл байхгүй ба тодруулахад зарим албан тушаалын тодорхойлолтыг дутуу боловсруулсан газрууд байна.

Тухайлбал:

- Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргаа;
- Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар;
- Саранхөхөө театр;
- Сумын Соёлын төвүүд.

Б.2. ТАСЗ нь сул орон тоог нийтэд зарлах үүргээ хангалттай хэрэгжүүлээгүйгээс төрийн байгууллагуудын үйл ажиллагааны тасралтгүй байдал алдагдах эрсдэл үүсэхээр байна.

Б.2.1. Аймгийн хэмжээнд 2019 онд төрийн байгууллагуудаас ТЖА-ны 166 ажлын байрны сул орон тооны захиалгыг ирүүлсэн ч сонгон шалгаруулалтын зарыг ТАЗ-д хүргүүлээгүйгээс тусгай шалгалтыг зохион байгуулаагүй байна.

Төрийн албаны ерөнхий шалгалтыг 2019 онд 187 иргэн, 2020 онд 368 иргэнийг тус тус хамруулан цахимаар зохион байгуулсан байна.

Төрийн албаны ерөнхий шалгалтад бүртгүүлсэн,
шалгалтад тэнцэж нөөцөд бүртгэгдсэн иргэдийн тоо

Хүснэгт №5

№	Ерөнхий шалгалт зохион байгуулсан он	Ерөнхий шалгалт зохион байгуулсан тоо	Бүртгүүлсэн иргэдийн тоо	Шалгалтад тэнцсэн иргэдийн тоо
1	2019 он	1	187	14
2	2020 он	1	368	118
Дүн			555	132

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 15 дугаар тогтоолоор баталсан Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журмын 3.1-т заасны дагуу аймгийн СЗ-өөс 2019, 2020 онд шалгалт зохион байгуулах үүрэг бүхий Салбар комиссыг 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллуулсан байна.

Дээрх журамд салбар комисс нь ТА-ны ерөнхий шалгалтад хамрагдах иргэний анкет, холбогдох бусад материалыг цахимаар хүлээн авч, шаардлагатай тохиолдолд баримт бичгийн үнэн зөвийг магадлах зорилгоор нэмэлт материал шаардах, шалгах эрх, үүргийг хэрэгжүүлэхээр заасан боловч аймгийн ТАСЗ-өөс шалгалт өгөхөөр бүртгүүлсэн иргэдийн шалгалт өгөх зарим болзол, шалгуурыг хангасан эсэхийг магадлах эрхээ хэрэгжүүлэх нөхцөл боломж бүрдээгүй, цахим бүртгэлд бүртгэгдсэн тухай баталгаажилтын хуудсаар тухайн иргэнийг ерөнхий шалгалт өгөх болзлыг хангасанд тооцон шалгалтыг зохион байгуулсан байна.

Тухайлбал: Ерөнхий шалгалт өгөх иргэдийн мэдээлэл нь ТАЗ-д цахим хэлбэрээр хүргэгдэн нэгтгэгдэж, зөвлөлөөс СЗ-д шалгалт өгөх иргэдийн бүртгэлийг хүргүүлж байгаа нь төрийн албаны ерөнхий шалгалт өгч байгаа иргэн нь дээд боловсролтой байх, цэргийн алба хаасан байх, тухайн орон нутагт төрийн жинхэнэ алба хаах хүсэлтэй байх гэсэн гол болзлыг хангаж буй эсэхийг магадлах боломж байхгүй байгаа нь МУ-ын Төрийн албаны тухай хуульд заасан ТЖАТ-д тавих нийтлэг шаардлагыг хангаж байгаа эсэх, МУ-ын иргэн төрийн алба хаах адил тэгш боломжоор хангагдах, ил тод байх төрийн албаны зарчим хэрэгжиж байгаа байдалд

орон нутгийн салбар зөвлөлөөс хяналт тавих, хуулийн дээрх заалтуудын хэрэгжилтийг хангуулах боломжгүй байна.

Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журмын 11.3, 11.4-т заасны дагуу Төрийн албаны зөвлөлөөс шалгалтын дүнг хэлэлцэн, “Төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэх тухай” тогтоолыг гаргаж, 2019 онд шалгалтад тэнцсэн 14, 2020 онд 118 иргэдийг төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэн, бүртгэлийн жагсаалтыг цахим хуудсанд байршуулсан байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 2.1-т “Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарснаас хойш долоо хоногийн дотор төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлнэ. Зөвлөл сул орон тооны мэдээллийг тухай бүр цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ”, 2.5-д “... сул орон тоо гарснаас хойш 21-ээс илүүгүй хоногийн дотор сонгон шалгаруулалт явуулах захиалгыг Зөвлөл, Салбар зөвлөлд харьяаллын дагуу ирүүлэх бөгөөд албан тушаалын тодорхойлолт, тухайн албан тушаалын сул орон тоо гарсныг нотлох шийдвэрийг хавсаргана” гэж заасан.

Аудитад хамрагдсан хугацаанд төрийн байгууллагууд сул орон тоо гарснаас хойш долоо хоногийн дотор төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлээгүй, 13 сумын ЗДТГ, СЗ-ийн харьяа 17 агентлагууд сул орон тоо гарсан тухай бүрд мэдээллийг журамд заасан нотлох шийдвэр, болон албан тушаалын тодорхойлолттой хавсаргаж ирүүлээгүй, 1 сумын ЗДТГ, 6 харьяа агентлаг сул орон тооны захиалга огт ирүүлээгүй байна. /Хавсралт№3/

Аймгийн ТАСЗ нь 2019 оны сул орон тооны судалгаанд 125 ажлын байрыг зарлахаар жагсаалт гаргасан байх боловч төрийн байгууллагуудаас ирүүлсэн албан бичгээс үзэхэд 139 сул орон тоог зарлуулахаар хүсэлт ирүүлсэн, харин албан бичгээр хүсэлт ирүүлээгүй 37 сул орон тоог СЗ судалгаанд оруулж бүртгэсэн байна.

**СЗ-ийн харьяа агентлаг, сумдын ЗДТГ-аас
ирүүлсэн сул орон тооны захиалга /2019 он/**

Хүснэгт №6

№	Захиалга өгсөн байгууллага	ТАСЗ-ийн судалгааны нэгтгэлийн дүн	2019 он		Нийт дүн
			Сул орон тооны мэдээллийг албан бичгээр ирүүлсэн	Сул орон тооны мэдээлэл ирүүлээгүй боловч судалгаанд нэгтгэгдсэн	
1	Сумдын ЗДТГ	49	64	12	66
2	Харьяа агентлаг, газар	63	73	14	87
3	ТҮ-ний байгууллагын ТШЗ	13	2	11	13
Дүн		125	139	37	166

Төрийн байгууллагуудаас 2019 онд 139 сул орон тооны ажлын байрны захиалгыг журмын 2.5-д заасны дагуу 21-ээс илүүгүй хоногийн дотор ирүүлсэн боловч ТАСЗ сонгон шалгаруулалт явуулах зарыг цахим сайтад байршуулаагүй, тусгай шалгалтыг зохион байгуулаагүй байна. Харин 2019 оны 166 албан тушаалын

сул орон тооны 20 орон тоо болон 2020 оны 30, нийт 50 орон тоог тус онд зарласан байна.

**Сумдын ЗДТГ, харьяа агентлаг, газруудаас
ирүүлсэн сул орон тооны захиалга /2020 он/**

Хүснэгт №7

№	Захиалга өгсөн байгууллага	ТАСЗ-ийн судалгааны нэгтгэл дүн	2020 он		Нийт дүн
			Сул орон тооны мэдээллийг албан бичгээр хүргүүлсэн	Сул орон тооны мэдээлэл ирүүлээгүй боловч судалгаанд нэгтгэсэн	
1	Сумдын ЗДТГ	-	-	-	-
2	Харьяа агентлаг, газар	-	19	6	25
3	Төрийн үйлчилгээний байгууллага	-	4	4	8
Дүн		-	23	10	33

Сумдын ЗДТГ-аас 2020 онд сул орон тооны захиалга ирүүлээгүй, харьяа агентлаг, газруудын нийт 33 сул орон тооны ажлын байрнаас 23 албан тушаалын сул орон тооны захиалгыг ирүүлсэн байх ба ТАЗ нь аймгийн СЗ-өөс хүргүүлсэн төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тооны захиалгыг үндэслэн нийт 5 удаагийн зараар, 2019, 2020 онуудын нийт 62 албан тушаалын сул орон тоог зарлаж нийтэд мэдээлэн, цахим хуудсанд байршуулсан байна.

**Төрийн албаны зөвлөлөөс нийтэд мэдээлж
зарласан сонгон шалгаруулалтын зар**

Хүснэгт №8

№	Шалгалт зохион байгуулах зарын төрөл	Цахим сайтад байршуулж нийтэд мэдээлсэн огноо					Нийт дүн
		2020.05.13	2020.05.19	2020.05.21	2020.10.01	2020.10.21	
1	Удирдах ажилтны сонгон шалгаруулалт	10		1		4	15
2	Гүйцэтгэх ажилтны сонгон шалгаруулалт		9		11		20
3	Төрийн үйлчилгээний байгууллагын ТШЗ			9		18	27
Дүн		10	9	10	11	22	62

Дээрх 62 албан тушаалын зараас 2 албан тушаалын сонгон шалгаруулалтыг хойшлуулсан, удирдах ажилтны 6, гүйцэтгэх ажилтны 6, төрийн үйлчилгээний байгууллагын ТШЗ-ийн 9, нийт 21 сул орон тооны мэдээллийг ТАСЗ-д ирүүлээгүй байна.

Аймгийн ТАСЗ-өөс 2019 онд төрийн албаны тусгай шалгалт зохион байгуулаагүй, 2020 онд Төрийн албаны зөвлөлийн цахим сайтад удирдах болон гүйцэтгэх ажилтны сонгон шалгаруулалтын сул орон тоог нөхөх зар тавигдсаны дагуу 25 албан тушаалд 28 иргэн бүртгүүлж оролцсон байна.

Удирдах ажилтны 6 албан тушаалын сонгон шалгаруулалтад 6 иргэн, гүйцэтгэх ажилтны 8 албан тушаалын сонгон шалгаруулалтад 10 иргэн тус тус оролцсон байна.

МУ-ын Төрийн албаны тухай хуулийн 23.2.3-т “Ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох бол төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх бөгөөд мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх”, мөн Төрийн албаны тусгай шалгалт өгөх журмын 3.2-т “Комисс нь анкет, холбогдох бусад материалыг цахимаар хүлээн авах, ажлын байранд тавигдсан шаардлагыг хангасан эсэхийг хянах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 4.1-т “албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан албан хаагч, иргэн шалгалтад бүртгүүлнэ” гэж тус тус заасан.

Гүйцэтгэх ажилтны албан тушаалын сонгон шалгаруулалтад оролцож шалгалт өгсөн иргэд нь тухайн албан тушаалын тодорхойлолтод заасан болзлыг бүрэн хангасан байна.

Харин удирдах ажилтны сонгон шалгаруулалтад оролцож шалгалт өгсөн иргэдээс дээр дурдсан шаардлага, болзлыг хангаагүй албан хаагчдыг тусгай шалгалтад оруулсан байна. /Хавсралт№4/ Үүнд:

- Мандах сумын ЗДТГ-ын даргын албан тушаалд материалаа ирүүлсэн иргэний Төрийн албаны тухай хуулийн 26.3-т заасны дагуу мэдлэг ур чадварыг харгалзан ажилласан жилийн тогтоосон шаардлагын 50 хувийг хангасан тул тухайн албан тушаалд үргэлжлүүлэн ажиллуулах тухай сумын Засаг даргын хүсэлтийн дагуу тусгай шалгалтын болзлыг хангасан гэж үзсэн.
- Аймгийн ЗДТГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн даргын сонгон шалгаруулалтад оролцсон иргэний ажилласан жил нь МУ-ын Төрийн албаны тухай хуулийн 23.2.3-т заасан ажилласан жилийг тогтоосон шаардлагад нийцээгүй байхад тухайн сул орон тоонд өөр оролцогч бүртгүүлээгүй гэх шалтгаанаар дээрх заалтыг зөрчин шалгалтад оруулсан байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ын 3.3-т “Комисс нь оролцогчийн анкет, холбогдох бусад материалыг хүлээн авах, ажлын байранд тавигдсан шаардлагыг хангасан эсэхийг хянах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 4.1-т “Албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан албан хаагчийг шалгалтад бүртгүүлнэ” гэж тус тус заасан.

Аймгийн ТАСЗ-өөс 2020 онд төрийн үйлчилгээний байгууллагын ТШЗ-ийн сонгон шалгаруулалтыг 2 удаа зохион байгуулж, нийт 11 албан тушаалын сонгон шалгаруулалтад 21 иргэн бүртгүүлж, 12 иргэн оролцсон байна.

2020.05.19-ний өдөр ТШЗ-ийн сонгон шалгаруулалтаар зарлагдсан 9 сул орон тоонд 11 иргэнийг бүртгэсэн ч аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга, Эрдэнэ сумын ЕБС-ийн захирал гэсэн 2 ажлын байрны сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, бусад 7 албан тушаалын сонгон шалгаруулалтыг зохион байгуулаагүй, энэ талаар хурлын тэмдэглэл хөтлөөгүй, 2020.10.01-ний өдөр зарлагдсан 9 сул орон тооны тусгай шалгалтыг зохион байгуулсан байна.

ТҮ-ний байгууллагын ТШЗ-ийн сонгон шалгаруулалтын тусгай шалгалтад Иххэт, Сайншанд сумын 13 дугаар цэцэрлэгийн сумын цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд материалаа ирүүлсэн иргэд нь дээр дурдсан шаардлага, болзлыг хангаагүй, тус албан тушаалд тавигдах тусгай шаардлагын багш, СӨБ-ын мэргэжил эзэмшээгүй байхад тусгай шалгалтад оруулсан байна.

Б.2.2. Ажлын байрны сул орон тоог нөхөхдөө журмын дагуу нэр дэвшүүлэхгүйгээр ТЖА-ны нөөцөд бүртгэлгүй иргэдийг томилсон байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 2.3-т “ТЖА-ны гүйцэтгэх, туслах албан тушаалын сул орон тоог шатлан дэвшүүлэх журмын дагуу, ТЖА-ны нөөцөд байгаа иргэдээс, нээлттэй сонгон шалгаруулалт зарлах дарааллаар нөхнө” гэж заасан.

СЗ-ийн харьяаны төрийн байгууллагуудад 2019 онд 166, 2020 онд 33, нийт 199 ажлын байрны сул орон тоог дээрх журмын дагуу хэрхэн нөхсөн байдлыг авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Ажлын байрны сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг 2019 онд зохион байгуулаагүй, харин 2020 онд 50 ажлын байрыг нөхөх 5 удаагийн шалгалтыг зохион байгуулж, 25 ажлын байрны сул орон тоог нөхсөн байх ба нэр дэвшүүлэхдээ дараах зөрчлийг гаргасан байна.
Аймгийн ТАСЗ-ийн 2020.10.08-ны өдөр зохион байгуулсан тусгай шалгалтаар хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчийн сонгон шалгаруулалтад оролцсон 2 иргэн нь албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангаагүй байхад тусгай шалгалтад оруулж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд нэр дэвшүүлэх тухай тогтоолыг хүргүүлсэн.
Аймгийн ЗДТГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн даргын сонгон шалгаруулалтад оролцсон иргэний төрийн албанд ажилласан хугацаа нь тогтоосон шаардлагыг хангаагүй, энэ тухай СЗ-өөс томилсон тусгай шалгалтын комиссын хурлаар ярилцсан ч ТАСЗ-өөс тус албан тушаалын сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлж, тогтоол гарган холбогдох байгууллагад хүргүүлсэн.
- Ажлын байрны сул орон тоог нөхөхдөө шатлан дэвшүүлэх журмын дагуу тухайн байгууллагад ажиллаж байгаа ТАХ-аас томилсон байдлыг авч үзэхэд Алтанширээ, Даланжаргалан сумдын Санхүүгийн албаны дарга, Даланжаргалан сумын ЗДТГ-ын даргыг МУ-ын ТАТХ-д заасан чадахуйн зарчим /мерит/-ыг үндэслэн томилсон байгаа хэдий ч томилогдсон иргэд нь удирдах албан тушаалын сул орон тооны сонгон шалгаруулалтад бүртгүүлээгүйгээс тусгай шалгалт зохион байгуулагдаагүй учир дээрх сул орон тоог нөхсөн гэх үндэслэлгүй байна.
- ТАЗ-ийн 2019.03.11-ний өдрийн 01 тоот албан даалгавраар төрийн зарим байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтнуудад тухайн байгууллагад хүний нөөцийн хууль бус томилгоог хуульд нийцүүлэх, залруулах үүрэг чиглэлийг хүргүүлсний дагуу СЗ-өөс сумд болон байгууллагуудад төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоонд төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалт, төрийн албаны мэргэшлийн шалгалт өгөөгүй иргэдийг ажиллуулахгүй байх чиглэлийг хүргүүлсэн байна.

Гэтэл сумдын ЗДТГ, харьяа агентлаг газрууд нь “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол журам”-ын 2 дахь заалтад заасны дагуу сул орон тоог нийтэд зарлаагүй, төрийн албаны ерөнхий шалгалт өгөөгүй, ТЖА-ны нөөцөд бүртгэгдээгүй иргэдийг томилон ажиллуулсан байна.

2019 онд ТАСЗ-д сул орон тооны сонгон шалгаруулалт явуулах талаар 6 сумын ЗДТГ-аас 20 орон тоо, 9 харьяа агентлаг, газруудаас 37 сул орон тооны захиалгыг албан бичгээр тус тус 2 удаа, 2020 онд 2 агентлагаас 2 албан тушаалын, 3 сумын ЗДТГ-аас 6 албан тушаалын сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар 3-4 удаа албан бичгийг хүргүүлсэн боловч аймгийн СЗ захиалгын дагуу сул орон тоог тухай бүр зарлаагүйгээс агентлаг, газруудын 21, сумдын ЗДТГ-ын 26, ТЖА-ны нөөцөд бүртгэгдээгүй 47 иргэнийг сул орон тооны ажлын байранд түр орлон гүйцэтгэгчээр томилон ажиллуулсан байна.

Түр орлон гүйцэтгэгчээр томилж ажиллуулсан
албан хаагчийн судалгаа

Хүснэгт №9

№	Агентлаг, сумдын ЗДТГ-ын нэрс	Томилсон ажилтны тоо
1	Нийгмийн даатгалын хэлтэс	6
2	Гэр бүл, хүүхэд залуучуудын газар	2
3	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	7
4	Хөдөлмөр халамж, үйлчилгээний газар	5
5	Боловсрол, соёл урлагийн газар	1
Нийт дүн		21
1	Айраг сумын Засаг даргын тамгын газар	3
2	Алтанширээ сумын Засаг даргын тамгын газар	1
3	Даланжаргалан сумын Засаг даргын тамгын газар	4
4	Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газар	2
5	Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газар	3
6	Мандах сумын Засаг даргын тамгын газар	2
7	Сайншанд сумын Засаг даргын тамгын газар	6
8	Сайхандулаан сумын Засаг даргын тамгын газар	3
9	Хөвсгөл сумын Засаг даргын тамгын газар	1
10	Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газар	1
Нийт дүн		26

ТАЗ-ийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан ТАЗ-ийн СЗ-ийн ажиллах журмын 3.3.2-т “СЗ нь ТА-ны нөөц бүрдүүлэх чиглэлээр төрийн байгууллага, албан хаагч, иргэдийг нөөцийн санд хамаарах мэдээллээр хангах, энэ талаар бүртгэл хөтлөх үүргийг хэрэгжүүлнэ” гэж заасан.

Гэтэл СЗ-ийн харьяа байгууллагуудаас 2019 онд 41, 2020 онд 19 байгууллагаас сул орон тооны захиалгыг ирүүлсэн байхад СЗ тус ажлын байрыг ТЖА-ны нөөцөөс бүрдүүлэх боломжтой эсэх талаар 11 төрийн байгууллагад мэдээлэл хүргүүлж ажилласан байна.

Сумдын ЗДТГ-ын сул албан тушаалд ажиллах АБТ-д заасан хүний нөөц ховор, мөн 2-4 удаа ТАСЗ-д сул орон тооны сонгон шалгаруулалт явуулах талаар албан бичгээр захиалга хүргүүлсэн ч сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажлыг дутмаг зохион байгуулснаас журмын дагуу удирдах, гүйцэтгэх албан тушаалыг нөхөх боломж нөхцөл бүрдэхгүй байна.

Аудитын явцад СЗ-ийн харьяа байгууллагуудаас санамсаргүй түүврээр 10 төрийн байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагааг авч үзэхэд дараах зөрчлүүд илэрлээ.

**Түүвэрт хамрагдсан байгууллагын 2019, 2020 онуудад
шинээр томилогдсон иргэний бүртгэл**

№	Байгууллагын нэр	Нийт шинээр томилсон	Үүнээс		Сул орон тооны захиалга өгсөн	Нөөцөд бүртгэлтэй иргэдээс томилсон	Хүснэгт №10 АТТ-д заасан шаардлага хангаагүй томилогдсон
			2019 онд томилсон	2020 онд томилсон			
1	ГХБХБГ	15	8	7	4	7	3
2	ГБХЗХГ	4	-	4	-	4	2
3	МХГ	16	2	14	13	2	-
4	ХХҮГ	10	4	6	4	-	-
5	БОАЖГ	2	2	-	1	2	-
6	ЭМГ	1	-	1	1	-	-
7	Аймгийн ЗДТГ	27	13	14	-	-	-
8	Сайншанд сумын ЗДТГ	15	6	9	7	8	3
9	Замын-Үүд сумын ЗДТГ	4	-	4	2	1	-
10	Аймгийн татварын хэлтэс	-	-	-	-	-	-
Дүн		94	35	59	32	24	8

Түүвэрт хамрагдсан байгууллагууд нийт 94 сул орон тооны 32 ажлын байрны захиалгыг ТАСЗ-д хүргүүлснээс 13 албан тушаалын захиалгын дагуу тусгай шалгалтыг зохион байгуулсан, ТЖА-ны нөөцөд бүртгэлтэй 24 иргэнийг томилсон байна. Харин сул орон тооны ажлын байранд шууд томилсон 57 иргэнээс 8 нь албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангаагүй иргэдийг томилсон ажиллуулсан байна. /Хавсралт №5/

Б.2.3 ТЖА-д нэр дэвшүүлсэн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий этгээд чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Төрийн албаны зөвлөлийн 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3.5.5-д “Нэр дэвшүүлсэн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавина” гэж заасан.

ТАСЗ-ийн гишүүдийн гүйцэтгэх ажил үүргийн хуваарьт хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд ТАЗ-өөс баталсан удирдамж, аргачлалын дагуу хяналт шинжилгээ хийх, ТАСЗ-өөс нэр дэвшүүлж санал болгох тухай тогтоолд холбогдох төрийн байгууллагуудад материалыг хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг СЗ-ийн нарийн бичгийн даргад үүрэг болгосон байна.

2020 онд нэр дэвшүүлсэн 25 иргэнийг тухайн албан тушаалд томилсон шийдвэрийн хуулбарыг ТАСЗ-д ирүүлэх талаар төрийн байгууллагуудад албан тоот хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй, шийдвэрийн хэрэгжилтэд СЗ-өөс хяналт тавьж ажиллаагүй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. ТАЗ-өөс томилсон ТАСЗ-ийн бүрэлдэхүүний 60 орчим хувь нь аймгийн ЗДТГ-ын бүтцийн нэгжүүдийн ажилтнуудаас бүрдсэн байна.
2. Салбар зөвлөлийн гишүүд нь жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг ажил үүргийн хуваарийн дагуу хариуцан зохион байгуулсан байдлыг тайлагнаагүй, ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнээгүй, хариуцлага хүлээлгэх асуудал орхигдсон байна.
3. Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хуралдааны шийдвэр тэмдэглэлийг зохих журмын дагуу албажуулах, СЗ-ийн архив, албан хэрэг хөтлөлтийг гүйцэтгэх үүргийг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.
4. Салбар зөвлөл нь үйл ажиллагаандаа шаардагдах зардлын төсвийн төсөөллийг боловсруулаагүй, аймгийн ЗДТГ-ын төсөвт тусгуулж батлуулаагүй, аудитад хамрагдсан хугацаанд нийт 12,2 сая төгрөгийг зарцуулсан байна.
5. ТАСЗ нь ТАТХ, тогтоомж, бодлого шийдвэрийг харьяа төрийн байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, ТАХ-ийн хэм хэмжээг сахиулах, сургалт, сурталчилгаа зохион байгуулах чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан боловч дээрх ажлуудын үр дүнг тайлагнах, баримтжуулах ажил хангалтгүй хийгдсэн байна.
6. Харьяа төрийн байгууллагуудаас ТАХ-ийн нөөцийн бүртгэл, хөдөлгөөнд орсон өөрчлөлтийн мэдээг батлагдсан загварын дагуу тухай бүр үнэн зөв, бүрэн хөтөлж СЗ-д ирүүлээгүйгээс ТАСЗ нь нөөцийн бүртгэл хөдөлгөөнийг бүрэн хөтлөөгүй байна.
7. ТЗАХ-д зэрэг дэв шинээр болон ахиулан олгох санал гаргах чиг үүргийн хүрээнд 2019 онд 96, 2020 онд 55 албан хаагчид тус нэмэгдлийг олгуулах саналыг гаргасан байх боловч 2019 оны архивын баримт материалыг гаргаж ирүүлээгүйгээс шаардлага хангасан албан хаагчид олгосон эсэх нь тодорхойгүй, харин 2020 онд үнэлсэн саналаас 26 албан хаагчийн өмнөх ангиллын албан тушаалд ажилласан хугацааны шаардлага хангагдаагүй байхад нэмэгдэл олгуулах санал гаргасан байна.
8. Аймгийн хэмжээнд 2019 онд ТЖА-ны 184 ажлын байрны сул орон тооны захиалгыг төрийн байгууллагуудаас ирүүлсэн ч ТАСЗ сул орон тоог нийтэд зарлах үүргээ хангалттай биелүүлээгүйгээс тусгай шалгалтыг зохион байгуулаагүй байна.
9. ТЖА-ны ажлын байрны сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтыг захиалгын дагуу тухай бүр зохион байгуулаагүйгээс ТЖА-ны нөөцөд бүртгэгдээгүй 47 иргэнийг түр орлон гүйцэтгэгчээр томилон ажиллуулсан, албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангаагүй төрийн албан хаагчдыг тусгай шалгалтад оруулж, нэр дэвшүүлэн томилсон байна.

Аудитаар илрүүлсэн зөрчлүүдийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтнуудад 8 зөвлөмжийг хүргүүлээ.

Төрийн албаны салбар зөвлөлд санал уламжлах тухай:

1. ТАЗ-ийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг ТЕЗ-ийн харьяа байгууллагууд болон аймгийн ЗДТГ-ын бүтцийн нэгжүүдийн ажилтнуудаас бүрдүүлэн томилж байгаа байдлыг өөрчлөн томилж, МУ-ын Төрийн албаны тухай хуульд заасан ил тод, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх гэсэн төрийн албаны зарчмыг хангах нөхцөлийг бүрдүүлэх.

Аймгийн төрийн албаны салбар зөвлөлд:

1. СЗ-ийн гишүүд нь ТАЗ-ийн салбар зөвлөлийн ажиллах журмын 4.3-т заасан эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллах, салбар зөвлөлийн дарга гишүүдийн ажил үүргийн биелэлтийг тухай бүр дүгнэж, шаардлага тавьж, хариуцлагажуулж, ажлын үр дүнг сайжруулах.
2. Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нь ТАЗ-ийн салбар зөвлөлийн ажиллах журмын 4.2-т заасан хуралдааны шийдвэр, тэмдэглэлийг зохих журмын дагуу хөтөлж албажуулах, архив, албан хэрэг хөтлөлтийг журмын дагуу хөтлөх, мэдээ, судалгааны үнэн зөв байдлыг хангаж ажиллах.
3. ТАЗ-ийн салбар зөвлөлийн ажиллах журмын 7.1, 7.2, 7.5 дахь заалтуудыг хэрэгжүүлж, СЗ-ийн үйл ажиллагаанд шаардагдах зардлын төсвийн төслийг боловсруулж, аймгийн ЗДТГ-ын төсөвт тусгаж батлуулах, үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргаж хэвших.
4. ТАСЗ нь сургалт, судалгаа, сурталчилгаа хийх чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд хийсэн ажлуудын бодит үр дүнг тайлагнах, баримтжуулж архивлах.
5. Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журамд заасны дагуу төрийн байгууллагуудаас ТЖА-ны хүний нөөцийн бүртгэл, хөдөлгөөнд орсон өөрчлөлтийн мэдээг батлагдсан загварын дагуу үнэн зөв гаргуулан тухай бүр авах, мэдээ тайлан гаргаж ирүүлээгүй байгууллага, албан тушаалтанд холбогдох хууль, журмын дагуу хариуцлага тооцох арга хэмжээ авч, нөөцийн бүртгэл хөдөлгөөнийг бүрэн хөтлөх.
6. ТАЗ-ийн салбар зөвлөлийн ажиллах журмын 3.8.2-т заасан ТЗАХ-д зэрэг дэв шинээр болон ахиулан олгох санал гаргах чиг үүргийг хэрэгжүүлэхдээ УИХ-ын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан журамд заасны дагуу ТА-д ажилласан болон тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, ТАТХ-ийн 23 дугаар зүйлд заасан тусгай шаардлагыг хангасан ТЗАХ-д тус нэмэгдлийг олгох саналыг дэвшүүлж байх.
7. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 2.1-т “Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарснаас хойш долоо хоногийн дотор төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлнэ. Зөвлөл сул орон тооны мэдээллийг тухай бүр цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ”, 2.5-д “... сул орон тоо гарснаас хойш 21-ээс илүүгүй хоногийн дотор сонгон шалгаруулалт явуулах захиалгыг Зөвлөл, Салбар зөвлөлд харьяаллын дагуу ирүүлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлж сул орон тоог нийтэд зарлах үүргээ хэрэгжүүлж, тусгай

шалгалтыг зохион байгуулан, төрийн албаны үйл ажиллагааны тасралтгүй үргэлжлэх зарчмыг хангаж ажиллах.

8. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.3, 4.1 дэх үүргийг хэрэгжүүлж албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг ТЖА-ны ажлын байрны сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтад оруулах, ТЖА-ны гүйцэтгэх, туслах албан тушаалын сул орон тоог шатлан дэвшүүлэх журам болон нөөцөд бүртгэлтэй иргэдээс нээлттэй сонгон шалгаруулалт зарлах дарааллаар нөхөх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГАН-ӨЛЗИЙ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг,
Утас: (705) 2-30-03,

2021.01.06 № 03
танай 2021.01.05 -ны № 1-6/02 -Т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Т.ГАН-ӨЛЗИЙ ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Дорноговь аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлийн 2019, 2020 онуудын үйл ажиллагаанд нийцлийн аудит хийгдсэнтэй холбогдуулан тус аудитын газраас ирүүлсэн тайлангийн төслийг хүлээн авч танилцлаа.

Миний бие нь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байсан бөгөөд Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 421 дүгээр тогтоолоор салбар зөвлөлийн даргаар томилогдож албан тушаалын чиг үүргээ баталгаажуулсан.

Түүнчлэн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Ц.Батсугир нь өөр ажил, албан тушаалд томилогдсонтой холбогдуулан нарийн бичгийн даргын сул орон тоонд холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд заасны дагуу шаардлага хангасан төрийн албан хаагчийг томилуулахаар судлан ажиллаж байна.

Ийнхүү аудитаар илрүүлсэн зөрчлүүдийг цаашид дахин давтахгүй байхад анхаарч, санал, зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах бөгөөд салбар зөвлөлөөс тус тайланд тусгагдсан дүгнэлт, зөвлөмжтэй холбоотой санал, хүсэлт байхгүй болно.



ДАРГА



Н.ХОНГОРЗУЛ

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД:

ГҮЙЦЭТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР		Э.ЭНХЦЭЦЭГ
АУДИТОР		Т.МӨНХТОГТОХ
ГЭРЭЭТ АЖИЛТАН		З.ДАВААНЯМ
ГЭРЭЭТ АЖИЛТАН		Б.АРИУНБААТАР

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН	
ГҮЙЦЭТГЭГЧ	Т.ГАН-ӨЛЗИЙ



АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/05

Дорноговь аймаг, Сайншанд сум

Нийцлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн Аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 20 дугаар зүйлийн 20.2, 20.3, 21 дүгээр зүйлийн 21.1, МУ-ын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан "ТАБ-ын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам", 2016 оны А/146 тоот тушаалаар батлагдсан "Нийцлийн аудитын түр журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалт, 2018 оны А/207 тоот тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагаа" сэдэвт нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, үр дүнг 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлэхийг ТАЗ-ийн Дорноговь аймгийн салбар зөвлөлийн даргад зөвлөсүгэй.
3. Аудитын тайланг Төрийн албаны зөвлөл болон аймгийн салбар зөвлөлд тус тус хүргүүлсүгэй.
4. Зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /У.Оюунтүлхүүр/-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Т.ГАН-ӨЛЗИЙ



440010135

Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагаас хүний нөөцийн мэдээлэл шинэчлээгүй, тухай бүр өөрчлөлт хийгээгүй төрийн байгууллагуудын судалгаа

Мэргэжлийн хяналтын газар

№	Овог нэр	Албан тушаалын нэршил	Ажилд томилогдсон огноо	Аудитаар 2019, 2020 онд томилогдсон иргэдийн түүвэрт	Тайлбар
1	Гончигжамцын Буяннэмэх	Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч	2017.07.18 Б/29	2020.11.02 Б/34	Төрийн захиргаа, эрсдлийн удирдлагын хэлтсийн даргаар томилж албан тушаалыг өөрчилснийг шинэчлээгүй.
2	Лувсангийн Бямбатуяа	Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч	2009.11.03 86	2020.06.18 Б/12	Эрүүл мэнд, боловсрол хүнсний хяналтын хэлтсийн дарга, улсын ахлах байцаагчаар томилж албан тушаалыг өөрчилснийг шинэчлээгүй.
3	Мөнхбаяр Маралмаа	Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч	2017.02.03	2020.08.12 Б/25	Ажилд томилогдсон огноог шинэчлээгүй
4	Хүдэрчулууны Дэлгэрцэцэг	Эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч	2018.07.02 Б/19	2019.11.08 Б/21	Ажилд томилогдсон огноог шинэчлээгүй
5	Гантулга Баясах	Эм био бэлдмэлийн хяналтын улсын байцаагч	2020.11.18 Б/38	2020.11.18 Б/38	Ажилд томилогдсон огноог шинэчлээгүй
6	Энхболд Хандсүрэн	Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналтын улсын байцаагч		2020.11.17 Б/36	Ажилд томилогдсон огноог шинэчлээгүй
7	Мягмарын Цэрэнням	Байгаль орчны хяналтын улсын байцаагч	2018.12.31 Б/32	2019.11.25 Б/24	Ажилд томилогдсон огноог шинэчлээгүй
8	Энхмэнд Анхбаяр	Геологи уул уурхайн хяналтын улсын байцаагч		2020.05.11 Б/08	Ажилд томилогдсон огноог шинэчлээгүй
9	Адъяагийн Гүндцэрэн	Барилгын техникийн хяналтын улсын байцаагч		2020.12.14 Б/46	Ажилд томилогдсон огноог шинэчлээгүй
10	Содномдаржаагийн Ган-Оргил	Автозамын хяналтын улсын байцаагч		2020.11.17 Б/37	Ажилд томилогдсон огноог шинэчлээгүй
11	Л.Алтансүх	Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч		2020.12.15 Б/47	Ажилд томилогдсон огноог шинэчлээгүй
12	Х.Болорчимэг	Замын-Үүд тасгийн хүнчний чанар стандартын улсын байцаагч		2020.07.20 Б/18	Ажилд томилогдсон огноог шинэчлээгүй
13	Б.Ганбаяр	Хүний нөөц, хууль эрх зүйн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн		2020.11.19 Б/39	Ажилд томилогдсон огноог шинэчлээгүй
14	Дансрангийн Эрдэнэжаргал	Автотээвэрэн хяналтын улсын байцаагч	2020.03.05 Б/04	2020.03.05 Б/04	Ажилд томилогдсон огноог шинэчлээгүй
15	Төмөрбаатарын Түвшинжаргал	Байгаль орчны хяналтын улсын байцаагч	2020.01.09 Б/01	2020.01.09 Б/01	Ажилд томилогдсон огноог шинэчлээгүй
16	Чоймболын Амарсанаа	Байгаль орчны хяналтын улсын байцаагч	2015.07.18 Б/22	2020.02.18 Б/03	Ажилд томилогдсон огноог шинэчлээгүй

2020 ОНД ЗЭРЭГ ДЭВ ШИНЭЭР БОЛОН АХИУЛАН ОЛГОСОН АЛБАН ХААГЧДЫН СУДАЛГАА

№	Албан тушаал	Эцэг/эх/-ийн нэр	Төрийн албанд ажилласан жил	Өмнөх ангилалд ажилласан жил	Тухайн албан тушаалд ажилласан жил	Үйл ажиллагаа, мэргэшлийн түвшингийн үнэлгээ	Олгуулахаар өргөн мэдүүлсэн зэрэг дэв	Одоогийн зэрэг дэв	Зэрэг дэв олгосон үндэслэл
Аймгийн Засаг даргын 2020.04.03-ны өдрийн А/292 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралтаар олгогдсон									
Ахлах түшмэлийн зэрэг дэв шинээр олгох									
1	Хөвсгөл сумын Засаг даргын Тамгын газрын дарга	Цэнд-Аюуш Март	10	ТЗ-3-0.11 ТЗ-9- 9.1	9	90 “А”	Дөтгөөр зэргийн ахлах түшмэл	Үгүй	Ажлын үр дүнг үнэлж, хугацааны шаардлага хангасан
Аймгийн Засаг даргын 2020.04.03-ны өдрийн А/292 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтаар олгогдсон									
Ахлах түшмэлийн зэрэг дэв ахиулан олгох									
2	Улаанбадрах сумын Засаг даргын Тамгын газрын дарга	Ангираг Мөнхцацрал	10	ТЗ-9-5.11	5.11	93.7 “А”	Дэд зэргийн ахлах түшмэл	Гутгаар зэргийн ахлах түшмэл 2017	Ажлын үр дүнг үнэлж, хугацааны шаардлага хангасан
3	Даланжаргалан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн Нарийн бичгийн дарга	Чулуунбат Соёл-Ундрах	10	ТЗ-5-1.4 ТЗ-9-8.0	8	90 “А”	Гутгаар зэргийн ахлах түшмэл	Дөтгөөр зэргийн ахлах түшмэл 2016	Ажлын үр дүнг үнэлж, хугацааны шаардлага хангасан
4	Эрдэнэ сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн Нарийн бичгийн дарга	Хашбат Цэрэндолгор	29	ТЗ-9-16.4	15	94.5 “А”	Тэргүүн зэргийн ахлах түшмэл	Дэд зэргийн ахлах түшмэл 2015	Ажлын үр дүнг үнэлж, хугацааны шаардлага хангасан

№	Албан тушаал	Эцэг/эх/-ийн нэр	Төрийн албанд ажилласан жил	Өмнөх ангилалд ажилласан жил	Тухайн албан тушаалд ажилласан жил	Үйл ажиллагаа, мэргэшлийн түвшингийн үнэлгээ	Олгуулахаар өргөн мэдүүлсэн зэрэг дэв	Одоогийн зэрэг дэв	Зэрэг дэв олгосон үндэслэл
Аймгийн Засаг даргын 2020.04.03-ны өдрийн А/292 дүгээр захирамжийн 3 дугаар хавсралтаар олгогдсон									
Дэс түшмэлийн зэрэг дэв шинээр олгох									
5	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Орон нутгийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн	Мэндбаяр Нандинцэцэг	17	ТЗ-5-4.10	1.11	86 “В”	Дөтгөөр зэргийн дэс түшмэл	Үгүй	Ажлын үр дүнг үнэлж, хугацааны шаардлага хангасан
6	Мал эмнэлгийн газрын Захиргаа, санхүүгийн албаны дарга	Ганхуяг Мөнхсарнай	5	ТЗ-5-4.10	1	92 “А”	Дөтгөөр зэргийн дэс түшмэл	Үгүй	Ажлын үр дүнг үнэлж, хугацааны шаардлага хангасан
7	БТСГ-ын Бодлогын хэрэгжилтийн ахлах мэргэжилтэн	Батбаяр Бат-Эрдэнэ	5	ТЗ-6-4.6	4.6	95 “А”	Дөтгөөр зэргийн дэс түшмэл	Үгүй	Ажлын үр дүнг үнэлж, хугацааны шаардлага хангасан
8	Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны дарга	Цоодол Саруулсайхан	20	ТЗ-3-2.0 ТЗ-7-3.3	3.3	“А”	Дөтгөөр зэргийн Дэс түшмэл	Үгүй	Ажлын үр дүнг үнэлж, хугацааны шаардлага хангасан
9	Хөвсгөл сумын ЗДТГ-ын Санхүүгийн албаны дарга	Түвшинбаяр Ууган-Эрдэнэ	4.2	ТЗ-3-0.4 ТЗ-6-3.8	3.8	90.3 “А”	Дөтгөөр зэргийн дэс түшмэл	Үгүй	Ажлын үр дүнг үнэлж, хугацааны шаардлага хангасан
10	ГӨДГСГЗ-ын мэргэжилтэн	Энхбаяр Пүрэв	11	ТЗ-3-0.11 ТЗ-5- 3.3	1.6	83.5 “В”	Дөтгөөр зэргийн дэс түшмэл	Үгүй	Ажлын үр дүнг үнэлж, хугацааны шаардлага хангасан

№	Албан тушаал	Эцэг/эх/-ийн нэр	Төрийн албанд ажилласан жил	Өмнөх ангилалд ажилласан жил	Тухайн албан тушаалд ажилласан жил	Үйл ажиллагаа, мэргэшлийн түвшингийн үнэлгээ	Олгуулахаар өргөн мэдүүлсэн зэрэг дэв	Одоогийн зэрэг дэв	Зэрэг дэв олгосон үндэслэл
11	Мал эмнэлгийн газрын Замын-Үүд сумын МЭТ-ийн дарга, улсын байцаагч	Болдбаатар Ууганжаргал	6	T3-3-3.11 T3-6-1.3	1.3	94 “А”	Дөтгөөр зэргийн дэс түшмэл	Үгүй	Ажлын үр дүнг үнэлж, хугацааны шаардлага хангасан
12	ХХҮГ-ын Зүүнбаян баг хариуцсан мэргэжилтэн	Цэдэндамба Мөнхцэцэг	5	T3-5-4.6	4.1	81.7 “В”	Дөтгөөр зэргийн дэс түшмэл	Үгүй	Ажлын үр дүнг үнэлж, хугацааны шаардлага хангасан
13	ХХҮГ-ын Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн	Пүрэв Ууганцэцэг	7	T3-5-7.0	1	85 “В”	Дөтгөөр зэргийн дэс түшмэл	Үгүй	Ажлын үр дүнг үнэлж, хугацааны шаардлага хангасан
Аймгийн Засаг даргын 2020.04.03-ны өдрийн А/292 дүгээр захирамжийн 4 дүгээр хавсралтаар олгогдсон									
Дэс түшмэлийн зэрэг дэв ахиулан олгох									
14	Мал эмнэлгийн газрын Мал амьтны эрүүл мэндийн албаны дарга	Уул-Өвгөн Мөнгөнхүү	15.11	T3-3-3. T3-5-1.1 T3-6-11.2 T3-9-0.8	1	93 “А”	Дэд зэргийн дэс түшмэл	Гутгаар зэргийн дэс түшмэл 2013	Ажлын үр дүнг үнэлж, хугацааны шаардлага хангасан
15	ХХҮГ-ын Хяналт-шинжилгээ хариуцсан мэргэжилтэн	Улаанмаам Эрдэнэтуул	10.1	T3-5-10.1	1.3	“В”	Гутгаар зэргийн дэс түшмэл	Дөтгөөр зэргийн дэс түшмэл 2017	Ажлын үр дүнг үнэлж, хугацааны шаардлага хангасан
16	БОАЖГ-ын Уул уурхай, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн	Дүгэрсүрэн Болормаа	15.5	T3-5-15.5	1.3	90 “А”	Дэд зэргийн дэс түшмэл	Гутгаар зэргийн дэс түшмэл 2013	Ажлын үр дүнг үнэлж, хугацааны шаардлага хангасан

№	Албан тушаал	Эцэг/эх/-ийн нэр	Төрийн албанд ажилласан жил	Өмнөх ангилалд ажилласан жил	Тухайн албан тушаалд ажилласан жил	Үйл ажиллагаа, мэргэшлийн түвшингийн үнэлгээ	Олгуулахаар өргөн мэдүүлсэн зэрэг дэв	Одоогийн зэрэг дэв	Зэрэг дэв олгосон үндэслэл
17	Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтэн	Халзанхүү Ариунтөгс	24.7	T3-5-14.3	14.3	100 “А”	Тэргүүн зэргийн дэс түшмэл	Дэд зэргийн дэс түшмэл 2017	Ажлын үр дүнг үнэлж, хугацааны шаардлага хангасан
18	Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтэн	Дорж Баржав	21.1	T3-5-13.4	13.4	91 “А”	Тэргүүн зэргийн дэс түшмэл	Дэд зэргийн дэс түшмэл 2017	Ажлын үр дүнг үнэлж, хугацааны шаардлага хангасан
19	Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтэн	Нооной Мөнхцэцэг	21.7	T3-5-14.3	14.3	92“А”	Тэргүүн зэргийн дэс түшмэл	Дэд зэргийн дэс түшмэл 2017	Ажлын үр дүнг үнэлж, хугацааны шаардлага хангасан
20	Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтэн	Эрхэмбаатар Нямцэцэг	21.10	T3-5-14.3	14.3	100 “А”	Тэргүүн зэргийн дэс түшмэл	Дэд зэргийн дэс түшмэл 2017	Ажлын үр дүнг үнэлж, хугацааны шаардлага хангасан
21	Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтэн	Цэндсүрэн Оюунтуяа	23.4	T3-5-14.3	14.3	92.2 “А”	Тэргүүн зэргийн дэс түшмэл	Дэд зэргийн дэс түшмэл 2017	Ажлын үр дүнг үнэлж, хугацааны шаардлага хангасан
22	Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтэн	Даваадорж Цацрал	27	T3-5-7.0	7	93.3 “А”	Дэд зэргийн дэс түшмэл	Гутгаар зэргийн дэс түшмэл 2017	Ажлын үр дүнг үнэлж, хугацааны шаардлага хангасан
23	Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтэн	Батсүх Хүдэрчулуу	22.6	T3-5-8.8	3.1	95 “А”	Гутгаар зэргийн дэс түшмэл	Дөтгөөр зэргийн дэс түшмэл 2019	Ажлын үр дүнг үнэлж, хугацааны шаардлага хангасан

№	Албан тушаал	Эцэг/эх/-ийн нэр	Төрийн албанд ажилласан жил	Өмнөх ангилалд ажилласан жил	Тухайн албан тушаалд ажилласан жил	Үйл ажиллагаа, мэргэшлийн түвшингийн үнэлгээ	Олгуулахаар өргөн мэдүүлсэн зэрэг дэв	Одоогийн зэрэг дэв	Зэрэг дэв олгосон үндэслэл
24	Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн	Сүрэнгочоо Энх-Амгалан	9.11	ТЗ-5-9.11	9.11	91 "А"	Гутгаар зэргийн дэс түшмэл	Дөтгөөр зэргийн дэс түшмэл 2016	Ажлын үр дүнг үнэлж, хугацааны шаардлага хангасан
25	Сайншанд сумын Захирагчийн ажлын албаны ахлах мэргэжилтэн	Батчулуун Энхчимэг	8.5	ТЗ-4-8.5	8.5	"В"	Гутгаар зэргийн дэс түшмэл	Дөтгөөр зэргийн туслах түшмэл 2019	Ажлын үр дүнг үнэлж, хугацааны шаардлага хангасан
26	Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны мэргэжилтэн	Зоригт Ариунжаргал	16	ТЗ-4-8.2	8.2	91 "А"	Гутгаар зэргийн дэс түшмэл	Дөтгөөр зэргийн Дэс түшмэл 2015	Ажлын үр дүнг үнэлж, хугацааны шаардлага хангасан

Сул орон тоо гарсан талаар албан бичиг ирүүлсэн ч нотлох шийдвэр болон албан тушаалын тодорхойлолт хавсаргаж ирүүлээгүй төрийн байгууллагууд

Д/д	Байгууллагын нэр	Сул ажлын байрны тоо
Харьяа агентлаг, газар		
1	Мэргэжлийн хяналтын газар	10
2	Хөдөө аж ахуйн газар	5
3	Орон нутгийн өмчийн газар	2
4	Боловсрол соёл, урлагийн газар	4
5	Эрүүл мэндийн газар	3
6	Мал эмнэлгийн газар	26
7	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар	9
8	Санхүүгийн хяналт, аудитын алба	2
9	Статистикийн хэлтэс	1
10	Стандарт, хэмжил зүйн хэлтэс	4
11	Гэр бүл хүүхэд залуучуудын газар	2
12	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	3
13	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	9
14	Нийгмийн даатгалын хэлтэс	3
15	Улсын бүртгэлийн хэлтэс	2
16	Замын-Үүд боомт дахь ХМХАлба	5
17	Аймгийн ЗДТГ	2
Нийт дүн		92

Д/д	Байгууллагын нэр	Сул ажлын байрны тоо
Сумдын ЗДТГ		
1	Айраг сумын Засаг даргын тамгын газар	2
2	Алтанширээ сумын Засаг даргын тамгын газар	9
3	Даланжаргалан сумын Засаг даргын тамгын газар	6
4	Дэлгэрэх сумын Засаг даргын тамгын газар	5
5	Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газар	5
6	Иххэт сумын Засаг даргын тамгын газар	3
7	Мандах сумын Засаг даргын тамгын газар	2
8	Өргөн сумын Засаг даргын тамгын газар	3
9	Сайншанд сумын Засаг даргын тамгын газар	14
10	Сайхандулаан сумын Засаг даргын тамгын газар	3
11	Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газар	5
12	Хөвсгөл сумын Засаг даргын тамгын газар	1
13	Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газар	6
Нийт дүн		64
Төсвийн шууд захирагч нар		
1	Замын-Үүд сумын соёл спортын ордны дарга	1
2	Өргөн сумын соёлын төвийн эрхлэгч	1
3	Сумдын эрүүл мэндийн төвийн дарга	4
Нийт дүн		6

Сул орон тооны захиалгыг албан бичгээр огт ирүүлээгүй ч ТАС3-ийн бүртгэлд бүртгэгдсэн төрийн байгууллагууд

Д/д	Байгууллагын нэр	Сул ажлын байрны тоо
Харьяа агентлаг, газар		
1	Аймгийн ИТХурал	2
2	Аймгийн татварын хэлтэс	3
3	Галба-Өөш долоодын говийн сав газрын захиргаа	3
4	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	4
5	Нийгмийн даатгалын хэлтэс	2
6	Мэргэжлийн хяналтын газар	6
Нийт дүн		20

Д/д	Байгууллагын нэр	Сул ажлын байрны тоо
Сумдын ЗДТГ		
1	Улаанбадрах сумын Засаг даргын тамгын газар	2
Нийт дүн		2
Төсвийн шууд захирагч нар		
1	Дэлгэрэх, Мандах сумын соёлын төвийн эрхлэгч	2
2	Сумдын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч	7
3	Сумдын ЭМТ-ийн дарга	2
4	Эрдэнэ, Өргөн сумын ЕБС-ийн захирал	4
Нийт дүн		15

ТЖА-ны удирдах ажилтны сонгон шалгаруулалтын мэдээлэл

[illegible]

Төрийн үйлчилгээний байгууллагын ТШЗ-ийн сонгон шалгаруулалтын мэдээлэл

Д/д	Захиалагч байгууллага	Овог нэр	Регистрийн дугаар	Албан тушаалын нэр	Ажлын байрны ангилал	Цахим сайтад зар тавигдсан огноо	Тусгай шалгалт зохион байгуулсан огноо	Оролцогчийн тоо	ТАЗ-ийн 25 дугаар тогтоолын 4.1.4 дэх заалт	Нэр дэвшүүлж, санал болгосон тогтоол	Тайлбар
1	Эрүүл мэндийн газар	Л.Баярмаа	ХП73071105	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга	ТҮЭМ-8	2020.05.19	2020.05.26	1	тийм		
2	Аймгийн ЗДТГ	Н.Насанжаргал	УТ86100881	НТБТ-ийн захирал	ТҮБД-5	2020.10.01	2020.10.08	1	тийм	2020.10.16-29 дүгээр тогтоол	
3		З.Энхцэцэг	ЕЮ76010400	НТБТ-ийн захирал	ТҮБД-5	2020.10.01	2020.10.08	1	тийм	Нөөцөд бүртгэгдсэн	
4	Иххэт сумын ЗДТГ	С.Энхмаа	ЕБ86011824	Иххэт сумын цэцэрлэгийн эрхлэгч	ТҮБД-5	2020.05.19 2020.10.01	2020.10.08	1	үгүй	2020.10.16-28 дугаар тогтоол	СӨБ-ийн бакалаврын боловсролгүй, нягтлан бодогч мэргэжлээр төгссөн байна.
5	Замын-Үүд сумын ЗДТГ	Б.Болортулга	АЮ71022563	Замын-Үүд сумын 7 дугаар цэцэрлэгийн эрхлэгч	ТҮБД-5	2020.10.01	2020.10.08	1	тийм	2020.10.16-23 дугаар тогтоол	
6		Л.Юмжирмаа	ХВ72030481	Замын-Үүд сумын 6 дугаар цэцэрлэгийн эрхлэгч	ТҮБД-5	2020.05.19 2020.10.01	2020.10.08	1	тийм	2020.10.16-24 дүгээр тогтоол	
7	Өргөн сумын ЗДТГ	С.Төгсжаргал	ЕА76031808	Өргөн сумын ЕБС-ийн захирал	ТҮБД-5	2020.05.19 2020.10.01	2020.10.08	1	тийм	2020.10.16-27 дугаар тогтоол	
8	Сайншанд сумын ЗДТГ	Х.Ариунтөгс	ЕЦ74021062	Сайншанд сумын 1 дүгээр ЕБС-ийн захирал	ТҮБД-5	2020.10.01	2020.10.08	1	тийм	2020.10.16-26 дугаар тогтоол	
9		О.Мөнхбаяр	ЕЮ72091029	Сайншанд сумын 14 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч	ТҮБД-5	2020.10.01	2020.10.08	1	тийм	2020.10.16-21 дүгээр тогтоол	
10		А.Энхээ	КЮ74011468	Сайншанд сумын 13 дугаар цэцэрлэгийн эрхлэгч	ТҮБД-5	2020.05.19 2020.10.01	2020.10.08	1	үгүй	2020.10.16-22 дугаар тогтоол	СӨБ-ийн бакалаврын боловсролгүй, СУИС дуу хөгжмийн багш мэргэжлээр төгссөн байна.
11		Х.Отгонбаяр	ЕП75080818	Зүүнбаян багийн ЕБС -ийн захирал	ТҮБД-5	2020.05.19 2020.10.01	2020.10.08	1	тийм	2020.10.16-25 дугаар тогтоол	
12	Эрдэнэ сумын ЗДТГ	Г.Баттуяа	ЕУ82121062	Эрдэнэ сумын ЕБС-ийн захирал	ТҮБД-5	2020.05.19	2020.05.26	1	тийм	2020.06.02-10 дугаар тогтоол	